

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны .... дугаар сарын .... өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

Зааварт өөрчлөлт оруулах тухай

Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг үндэслэн  
ТУШААХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны А/72 дугаар тушаалаар баталсан  
“Иргэний болон харуул, хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах  
аюулгүй ажиллагааны сургалтын заавар”-ын 4.2 дахь хэсгийн “б” дэх заалтын “төгссөн диплом,  
дипломын хавсралт” гэснийг “төгсөж, олгосон баримт бичиг, түүний хавсралт” гэж өөрчилсүгэй.

2.Тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг алба, нэгж, нутаг дэвсгэрийн  
байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын  
Тэргүүн дэд дарга /цагдаагийн хурандаа Ц.Ням-Очир/-д даалгасугай.

4.Тушаалыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД